

## **МОНГОЛ УЛС, ЕВРОПЫН ХОЛБООНЫ ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА: ӨНӨӨГИЙН ТҮВШИН БА ИРЭЭДҮЙ**

*Л.Оюунгэрэл\**

### **Монгол ба Европын Холбооны хамтын ажиллагааны гол үр дүн**

1989 оны 8 сарын 1-нд БНМАУ, Европын Эдийн Засгийн Хамтын Нийгэмлэг (ЕЭЗХН)-ийн хооронд дипломат харилцаа тогтоож, улмаар 1990 онд Европын Комиссын ажлын хэсгийн анхны төлөөлөгчид Монголд айлчилж, 1991 онд Европын Холбооны анхны Элчин сайд Итгэмжлэх Жуж Бичгээ барьснаас хойш бараг хориод жил болох гэж байна. Энэ хугацаанд Монгол Улс, Европын Холбооны харилцаа, хамтын ажиллагаа тогтмол шинжтэй болж доорх гол үр дүнд хүрчээ.

Нэг. 1991 онд Монгол Улс, Европын Холбооны хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт үзэглэж улмаар 1992 онд гарын үсэг зурав. Европын Холбоо Монголтой харилцахдаа худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг анхаарч 1991 онд ЕХ-ны Худалдааны хөнгөлөлтийн ерөнхий системийн (GSP) зохицуулалтад хамруулж, улмаар 1993 онд хоёр талын хооронд байгуулах Сүлжмэл, нэхмэл эдлэл худалдаалах хэлэлцээрт үзэглэж, 1998 онд Монголоос ЕХ-нд нийлүүлэх ноолууран болон оёмол эдлэлд тогтоосон тооны хязгаарлалтыг цуцлав. Түүнчлэн 1997 онд Монгол Улс, Европын Холбооны хамтын ажиллагааны хамтарсан хорооны дэргэд Монголд Европын хөрөнгө оруулалтыг өсгөх, худалдааг нэмэгдүүлэх зорилгоор Дэд хороо байгуулжээ.

Европын Холбоо бол Монгол Улсын хувьд худалдааны зургаа дахь том түнш юм. 2000 оны үзүүлэлтээр ЕХ, Монголын худалдааны эргэлт 115 сая еврод хүрчээ. ЕХ-ны орнуудын Монголоос импортолж байгаа гол нэрийн бараа нь ноос, ноолууран бүтээгдэхүүн юм. Харин ЕХ-оос Монголд экспортолж байгаа гол бүтээгдэхүүнд тоног төхөөрөмж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, химийн бодис орж байна. Европын Холбоон дахь Монголын гол түншлэгчид нь импортын хувьд Итали, Англи, харин экспортын хувьд Герман улс юм. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын гадаад худалдааны хэмжээ нэмэгдэж экспортын 10 хувийг, импортын 8 хувийг Европын Холбоо эзэлж байна.

---

Л.Оюунгэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Ийнхүү арав гаруй жилийн хүчин чармайлтын үр дүнд 2002 он гэхэд хоёр талын худалдааны эргэлт 2 дахин өссөн байна. Харин Европын Холбооноос Монголд хөрөнгө оруулж буй хэмжээг Монгол, Европын Холбооны хамтарсан хорооны дэргэдэх Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих дэд хорооны хурлаар (2002) хоёр тал хангалтгүй (7 хувь) гэж үзэж анхаарч ажиллах тухай ярилцжээ.

2005 оны 7 сарын 1-ээс эхлэн Монголд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг Европын Холбооны зах зээлд татваргүйгээр гаргах тухай шийдвэр гаргаж ЕХ манай улсад маш чухал хөнгөлөлт үзүүлэхээр болов. Энэ эрх зургаан сарын хугацаатай ба энэ хооронд Монгол Улс хүлээсэн үүргээ биелүүлсэн тохиолдолд ирэх гурван жилд татварын хөнгөлөлт үйлчлэх ба улмаар 10 жил хүртэл сунгах боломжтой ажээ. Монголын бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, дэлхийн ба Европын Холбооны зах зээлийн мэдээллээр хангах зорилгоор Үйлдвэр, худалдааны яамны дэргэд Олон улсын худалдаа, зах зээл судлалын төв байгуулагдсан ба уг төв дээр ЕХ-ны Европын Комиссоос Азийн итгэлцлийн сангаар дамжуулан төслөө санхүүжүүлэх ажээ. Монголд үйлдвэрлэсэн мал аж ахуй, хөдөө аж ахуй, барилгын үйлдвэрлэл, аж үйлдвэр, гоёл чимэглэл зэрэг үндсэндээ бүхий л салбарын 7200 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн татварын хөнгөлөлтөнд хамрагдах болсон нь Монголын бизнесменүүдэд Европын Холбооны зах зээлд хүчээ сорих, Монголын экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах сайхан боломж нээгдэж байна. Гадаад, дотоодын ямар ч хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн уг шийдвэрт хамрагдаж болно. Энэ нь Европын Холбооны гишүүн орнуудын Монголд хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжийг бас нээж байна.

Европын Холбооны гишүүн орнуудын Монголд оруулсан хөрөнгө оруулалт бас ч чамлахааргүй түвшинд хүрч байна. 1990-2003 онд Европын Холбооны гишүүн орнуудаас Монголд хөрөнгө оруулалт хийсэн байдлыг авч үзвэл анх 1993 онд Франц, 1994 онд Португалийн тус бүр нэг компани, улмаар 1995 онд Швейцари, Болгар, Итали, Унгар, Бельгийн компани Монголд хөрөнгө оруулалт хийж бизнесийн салбар дахь хамтын ажиллагаагаа эхэлжээ. 90-ээд оны дунд үеэс Монголд хөрөнгө оруулсан компанийн тоо нэмэгдэж өнөөдөр Францын 14, Япон, Францын хамтарсан 2 компани - (1997, 2001 онд), Канад, Францын хамтарсан нэг компани (2001), Болгарын 11, АНУ-тай хамтарсан нэг компани (2000), Сингапуртай хамтарсан нэг компани, Италийн 11, Унгарын 7, Бельгийн 5, Испанийн 4, Испани, Хятадын хамтарсан нэг компани, Португалийн 1, АНУ, БНХАУ-тай хамтарсан нэг компани тус тус ажиллаж байна.

Монголд Европын Холбооны хөрөнгө оруулалттай 90 компани ажиллаж байгаа бөгөөд нийт 36 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгээд байна. Энэ нь Монголд оруулсан гадаадын нийт хөрөнгө оруулалтын 9 гаруй хувь бөгөөд Европын Холбоо нь Монголд хөрөнгө оруулалт хийж байгаа БНХАУ (нийт хөрөнгө оруулалтын 37.9 хувь), Канад (нийт хөрөнгө оруулалтын 15.2 хувь), БНСУ-ын (нийт хөрөнгө оруулалтын 9.3 хувь) дараа орох 4 дэх том түнш болоод байна. Монголд оруулж буй нийт хөрөнгө оруулалтын 6.9 хувийг Япон, 4.1 хувийг АНУ, 3.9 хувийг ОХУ эзэлж буйтай харьцуулвал Монголын хөгжил дэвшилд Европын Холбооны гүйцэтгэх үүрэг тодорхой харагдаж байна. Европын Холбооны улсуудын хөрөнгө оруулалтыг улс тус бүрээр нарийвчлан судалж нэмэгдүүлэх нөөц боломж байгаа билээ.

Хоёр. Монгол Улс, Европын Холбоо хоорондын харилцаа, хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэхэд улс төрийн хүчин чармайлтыг идэвхжүүлэх шаардлагатай байна. 1994 онд Европын Парламент Монголын улс төрийн байдлын тухай 9 заалт бүхий шийдвэр гаргасан бөгөөд уг тогтоолд “Улс төрийн яриа хэлцээ нь Монголд ардчиллыг бэхжүүлж улмаар бүс нутгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд дөхөм болохыг харгалзан тус нийгэмлэг нь (Европын хамтын нийгэмлэг) хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Төв Азийн орнуудтай байгуулж буйтай адилаар түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээрийг байгуулах чиглэлээр ажиллахыг зүйтэй гэж үзэж байна” гэжээ. Тиймээс ийм хэлэлцээрийг жинхэнэ ажил хэрэг болгох талаар санаачилгатай ажиллах явдал чухал болж байна. Монголын тал энэ чиглэлд анхаарч 2002 оны 9 сард болсон “Гадаад харилцааны үр өгөөжийг дээшлүүлье” сэдвээр Монгол Улсаас хилийн чанадад суугаа ДТТ-ын тэргүүн нарын зөвлөлгөөн дээр “Европын Холбоотой Монгол Улс найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээтэй болох асуудлыг судлан үзэх нь зүйтэй” гэж тэмдэглэв.<sup>1</sup> 2004 оны 12 сард Монгол Улсын Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Гадаад хэргийн сайд нарын 12 дахь удаагийн уулзалтанд оролцсон ба ЕАБХАБ-ын байнгын зөвлөлийн шийдвэрээр Монгол Улсад Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын хамтран ажиллагч түнш орны статус олгосон нь хоёр талын харилцаа гүнзгийрч байгаа нэг жишээ юм.

Олон улсын хамтын нийгэмлэг, тухайлбал НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс 2005 онд хийсэн судалгаагаар Монгол нь дэлхийн хөгжиж байгаа 112 улс орноос эдийн засаг, экологийн эмзэг өртөмтгий байдал,

хүний аюулгүй байдлын түвшнээр нэн эмзэг 20 улсад орох болжээ.<sup>2</sup> Тиймээс олон улсын хамтын нийгэмлэг Монголыг НҮБ-аас томъёолсон “Нэн буурай хөгжилтэй улс орон” гэхээс илүү “Далайд гаршгүй хөгжиж байгаа улсын” статусыг эдэлж тус бүлгийн улс орнууд, тухайлбал Швейцари, Австри, Чех, Унгар болон Азийн далайд гаршгүй улс орнуудтай эдийн засаг ба техникийн хэлхээ холбоогоо гүнзгийрүүлвэл үр дүнтэй байж болно гэж үзэх болжээ.<sup>3</sup> Тэр бүлгийн улс орнуудыг гадаадын зөвлөхүүд “шинэ гуравдахь хөрш” ч гэж нэрлэж байна.<sup>4</sup> Тэдгээр улсын зарим нь Европын Холбооны гишүүн гэдгийг ч бодсон Монгол Улсын Европын Холбоотой тогтоосон харилцаа, хамтын ажиллагаа нь Монголын тусгаар тогтнолыг бэхжүүлэх, эдийн засгийн хөгжлийг хангахад нэн чухал юм.

### **Европын Холбооны Монголд үзүүлж буй тусламж**

Өнөөдөр дэлхий даяар өндөр хөгжилтэй улс орнуудаас хөгжиж буй орнуудад үзүүлж буй тусламжийн тэн хагасаас илүү хувь Европын Холбоонд ногдож байна.

Монголд хөгжлийн албан ёсны тусламж үзүүлж буй гол хандивлагчид: 1. Япон, 2. АНУ, 3. Герман, 4. Европын Холбоо, 5. Азийн хөгжлийн банк, 6. НҮБХХ юм. Европын Холбоо нь Монголд хөгжлийн албан ёсны тусламж үзүүлж буй гол улсууд - Япон, АНУ, Германы дараа орох 4 дэх гол хандивлагч юм. 1991-2002 онд Европын Холбооноос Монголд нийт 42,20 сая ам.долларын хөгжлийн албан ёсны тусламж үзүүлээд байна.<sup>5</sup>

1994 оноос Монгол Улс нь Европын Холбооноос хэрэгжүүлж буй Тасисын хөтөлбөрт нэгдэн орж нийт 50 сая еврогийн тусламж авчээ. Энэхүү хөтөлбөр Монгол Улсын улс төрийн эрх чөлөө, эдийн засгийн хөгжил цэцэглэлтийг баталгаажуулах эрмэлзэл, санаачилгад нь тус дэм болоход чиглэгджээ. Тасис хөтөлбөрийн хэрэгжилтийг авч үзвэл:

- 1994-1995 онд хүний нөөцийн хөгжил, жижиг дунд үйлдвэр, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх, эрчим хүчний салбарыг голлож байв.

- 1996-1999 онд Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт, үйлдвэрийн газар, санхүүгийн хөгжил, дэд бүтцийн хөгжил

- 2002-2003 онд хөдөөгийн жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих, шилжилтийн үеийн нийгмийн үр дагаврыг арилгах (ялангуяа сонгож авсан аймгуудын ажилгүйдлийг бууруулах), байгаль хамгаалах (тухайлбал, бэлчээрийн даац хэтрэхээс сэргийлэх аргууд) гэсэн 3 үндсэн чиглэлд тусламж үзүүлжээ.

1995 оноос хойш ЕХ-ны шугамаар Ардчилал хөтөлбөрийн төслүүдийг хэрэгжүүлсэн ба Хүний эрхийг бодитоор хэрэгжүүлэх, үндэсний цөөнхийг хамгаалах, иргэний нийгмийн байгууллагуудыг хөгжүүлэх, ардчилсан аж төрөх есыг хэрэгжүүлэх зэрэг чиглэлд анхаарчээ.<sup>6</sup>

- 2004-2006 онд Европын Холбооноос 10 сая еврогийн тусламж үзүүлэх болсон бөгөөд Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, Ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх зээл болон бусад жижиг үйл ажиллагааг санхүүжүүлэх юм.

Европын Холбоо нь сүүлийн хэдэн жил зудад нэрвэгдсэн малчдад зориулж хүнсний бүтээгдэхүүн, эмийн шуурхай тусламжаас гадна малын тэжээл, ногооны үр олгож туслав. 1999-2000 онд Европын Холбооноос Монгол Улсад 1,8 сая евро, 2000-2001 онд 1,03 сая еврогийн хүмүүнлэгийн тусламж үзүүлжээ.

2004 оны 1 сарын 1-ээс эхлэн Монгол Улс АПА-гийн тусламжийн хөтөлбөрт хамрагддаг болов. Ази, Латин Америкийн хөгжиж байгаа орнуудад туслах зорилгоор хэрэгжүүлж байгаа АПА хөтөлбөрийг нийт 32 улсад хэрэгжүүлж байна. АПА-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хөтөлбөрүүд нь ТАСИС-ынхаас илүү өргөн хүрээтэй болох юм. АПА-гийн хүрээнд хоёр талын хамтын ажиллагаанаас гадна Азийн олон улс орны хоорондын өрсөлдөөн өндөр байх учраас Монголын байгууллагууд үндэслэл сайтай төсөл боловсруулах шаардлагатай болж байна. АПА-ийн хүрээнд олон талын хамтын ажиллагааны доорх хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

1. Азийн хөрөнгө оруулалт. Европын Холбоо, Азийн бизнесийн хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэхэд чиглэсэн санхүүжилт юм.

2. Азийн холбоо. ЕХ, Азийн дээд боловсролын байгууллагуудын бүсийн болон олон талт хамтын ажиллагаа, харилцааг дэмжихэд чиглэгдсэн хөтөлбөр юм.

3. Ази Про Эко. ЕХ, Азийн хоорондын харилцан ашигтай үйл ажиллагаа, ойлголцлыг дэмжих замаар байгаль орчны хамгаалал, эдийн засгийн салбарын технологийн түншлэл, тогтвортой хөрөнгө оруулалтыг дэмжих зорилготой ажээ.

### **ЕХ-ны хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслүүдэд Монгол Улсын оролцоог хэрхэн дээшлүүлж, үр ашгийг нь нэмэгдүүлэх вэ?**

Европын Холбоо, Монгол Улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудалд хоёр тал анхааран ажиллаж байна. Европын Комиссын Бээжин дэх Суурин төлөөлөгчийн газраас 2004 оны 9 сарын

28-29 нд “Европын Холбоо, Монгол Улс хоорондын хамтын ажиллагааны боломжууд” сэдвээр семинар зохион байгуулж хэлэлцүүлсэн нь ЕХ-ны хөтөлбөр, төслүүдтэй Монголын холбогдох байгууллагууд, өргөн олон нийт танилцах, хоёр талын хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой болов. Европын Холбоо нь Монголын хөгжил дэвшилд чухал гол түншийн нэг учраас Монголын байгууллагууд доорх хэд хэдэн асуудал дээр анхаарууштай.

Нэг. Монголын байгууллагууд Европын Холбооноос Азийн хөгжиж байгаа орнуудын талаар баримталж буй бодлогыг ажиглаж, АПА-гийн хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслүүдэд судалгаа, мэдээлэлтэй хандаж идэвхи, санаачилгатай ажиллах хэрэгтэй байна. АПА-гийн 2004 онд Европын сэргээн босголт хөгжлийн банк манай улсыг зээлжих эрхтэй орнуудын тоонд оруулах шийдвэр гаргасан нь Монголд ЕХ-ны томоохон төслүүдийг хэрэгжүүлэх боломж олгож байна. Харин энэ асуудалд нилээд судалгаатай хандаж бусад орны туршлагыг ч харгалзах хэрэгтэй мэт. Европын хөрөнгө оруулалтын Банкны зээл олгох алба Монголыг Бангладеш, Индонез, Балба, Пакистан, Шри Ланка, Йемен улсуудтай нэг бүлэгт оруулсан ба тэдгээрээс Бангладешт 36 сая еврогийн цементийн үйлдвэр байгуулах төсөл, Шри-Ланкад 40 сая еврогийн жижиг, дунд хэмжээний төсөл хэрэгжүүлэх, Пакистанд 43 сая еврогийн газрын тосны дамжуулах хоолой барих төсөл хэрэгжүүлжээ. Харин Монгол, Балба зэрэг улсад одоохондоо төсөл хэрэгжүүлээгүй байна.

Хоёр. Европын Холбооны албан есны тусламжийн бодлогыг судалж Монголд хэрэгтэй арга хэлбэрүүдийг сонгож авах хэрэгтэй байна. Энд юуны өмнө ЕХ-ноос хөгжиж байгаа орнуудын төсөвт дэмжлэг үзүүлэх тусламжийн шинэ хэлбэрийн тухай ярьж байна. 1999 оноос эхлэн ЕХ нь албан ёсны тусламж үзүүлэхдээ үр дүнг үндэслэсэн шинэ үзэл баримтлал баримтлах болов. Үүний нэг өвөрмөц хэлбэр бол төсөвт үзүүлэх дэмжлэг юм.

Тухайн улсын төсөвт шууд мөнгө шилжүүлж туслах нь бодлогын чиглэлүүдийг хэрэгжүүлэх үйл явцыг идэвхжүүлэх, улс орны үндэсний чадавхийг нэмэгдүүлэх, төрийн захиргааны байгууллагуудын чадавхийг дээшлүүлэхэд ач холбогдолтой юм.

Тусламж үзүүлж буй орнуудын төсөвт дэмжлэг үзүүлэхдээ Европын Холбоо доорх 4 нөхцлийг шаардаж байгаа ажээ. Үүнд:

1. Тухайн улс орны макро эдийн засгийн тогтвортой байдал. Тусламж хүртэгч улс Бретон Вүүдсийн байгууллагуудын дэмжлэгийг

авсан, макро эдийн засгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой. Товчоор хэлэхэд ОУВС-гийн зээлд хамрагдсан байх ёстой.

2. Тухайн улс ядуурлыг бууруулах улс төрийн тов тодорхой хүсэл эрмэлзэлтэй байх бөгөөд ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлнэ.

3. Тусламж хүртэгч улсын төсвийн бодлого ил тод байж үр ашигтай байх ёстой. Тухайн улсын төсвийн удирдлагад үнэлгээ өгөхдөө Европын Холбоо нь Дэлхийн Банк ба ОУВС-гийн дүн шинжилгээг иш үндэс болгох ажээ.

4. Тухайн улс оронд үзүүлж буй тусламжийн үр ашгийг гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээр хэмжих ажээ. Дээрх дөрвөн нөхцлийн эхний гурав нь бусад хандивлагчдын тавьдаг шаардлагатай ижил юм. Харин дөрөв дэх нөхцөл нь тухайн улс орны бодлого хэр үр ашигтай байгааг иш үндэс болгосноороо бусад хандивлагчдынхаас ялгаатай, ЕХ-ны албан ёсны тусламжийн бодлогод гарч байгаа өөрчлөлтийг тусгаснаараа онцлог юм.

ЕХ-ны төсөвт дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийг гурван жилийн хугацаатай хэрэгжүүлж байна. Тусламж хүлээн авагч улс Ядуурлыг Бууруулах Стратегийн баримт бичигтээ бодлогын гол гол салбараар тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлж хөрөнгө, нөөцийн ашиглалтыг зохих ёсоор төлөвлөж хэрэгжүүлнэ. Европын Холбооны тусламжийн энэ хэлбэрийг авахын тулд манай улс ЕХ-той юуны өмнө түншлэлийн гэрээ байгуулсан байх ёстой. Монголын хувьд тусламжийн энэ хэлбэр юугаараа давуу талтай вэ? гэвэл бодлогын чиглэлүүдийг өөр хооронд нь уялдуулан холбох, нийгмийн салбарыг илүү анхаарах, мөн тусламжийн үр ашигт үнэлгээ өгөх шалгуурууд илүү тодорхой болох юм.

### **ЗҮҮЛТ, ИШЛЭЛ**

1. Гадаад харилцаа, 2002 оны 9 сар, №14, х. 32
2. Economic and Ecological Vulnerabilities and Human Security in Mongolia, UNDP Mongolia, 2005, p.61
3. *ibid.*, p. 54
4. *ibid.*, p.54
5. Human Development Report, Mongolia, 2003, p. 52
6. <http://europa.eu.int/comm/europeaid/projects/tacis/index.en.htm>